

ЭНЭТХЭГИЙН БИЛИГ БАРАМИДЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ҮЕ ШАТУУД

Б. Түшихбаяр - МУИС. НШУС. Шашин судлалын тэнхим, докторант

Түлхүүр үг: Бурханы шашны философи, Билиг барамид, Судрын аймаг, Номын хүрдэн, Их хөлгөн, Их тэрэгтэн

Товч утга: Бурханы шашны Их хөлгөний ёсны гол номлол нь Билиг барамидын сургаал мөн юм. Их хөлгөний энэхүү ёсыг Бурхан багш Ражикэр хотын зүүн хойно орших Тас цогцолсон нэрт ууланд өөрийн гол шавь Шарипутра, Ананда тэргүүтэй 1250 хуврага шавь нар ба энгийн сүсэгтэн олонд номлосноор Их хөлгөний номлолыг дэлгэрүүлжээ. Энэхүү өгүүлэлд Их хөлгөний ёс Бурхан багшийн үед хэрхэн анх дэлгэрч байсныг тодорхой өгүүлжээ. Ингээд тус ёс хэсэг хугацаанд тасалдаад дахин дэлгэрсэн юм. Мөн өгүүлэлд Их, Бага хөлгөний ёсны ялгааг гаргахын хамт Бурханы айлдсан Билиг барамидийн сургаалын тухай өгүүлсэн байна.

1. Билиг барамидийн сургаалын үндсэн ухагдахуун

Бурханы шашны Их хөлгөний ёсны сургаалд нирваан буюу гэгээрэлд хүрэх арга нь судар, тантрын хоёр зам мөр бий. Тэгвэл судрын ёсны гэгээрлийн мөр нь Билиг барамидыг хэрхэн эзэмших хийгээд дадуулахтай холбогдоно. Энэ тухай өгүүлэхийн тулд Их, Бага хөлгөний хоёр ёс хэрхэн үүссэн түүхийг дурдах шаардлага гарч ирдэг.

Бурхан багш мээ 480 онд¹ Энэтхэг оронд мэндлээд 36 нас сүүдэртэйдээ төгс гэгээрэлд хүрч анхны таван шавьдаа анхдугаар номын хүрдийг дөрвөн үнэний сургаалаар эргүүлснээр Тхеравада буюу Бага хөлгөний ёс анх дэлгэрсэн юм. Үүний хойш Ражикэр хотын зүүн хойно орших Тас цогцолсон нэрт ууланд хоёр дахь номын хүрдээ өөрийн гол шавь Шарипутра, Ананда тэргүүтэй 1250 хуврага шавь нар ба энгийн сүсэгтэн олонд Билиг барамидийг номлосноор Их хөлгөний номлолыг дэлгэрүүлжээ. Энэхүү номын хүрдний ёслолоор Билиг барамидийн сургаал дэлгэрсэн билээ. Энэ тухай Брагри Дамцагдорж "Тас цогцолсон уулнаа дэлгэрэнгүй, дунд, хураангуй гурван "Юм" тэргүүтэн дундад билиг чанар үгүйн номын хүрдийг эргүүлэв" гэж тодорхойлсон байдаг². Бурхан багшийн "Юм"-ын есөн ном нь билиг барамидийн бүрэн тайлбар бөгөөд тэдгээрээс уламжлагдаж бидний үед хүрч ирсэн долоон ном Бурхан багшийн зарлигийн эмхтгэл болох Ганжуурт байдаг.

Их хөлгөний ёс буюу Махаяна гэсэн нэр томъёо тус шашин дахин дэлгэрсэн буюу МЭ-ний II зууны үеэс өргөн хэрэглэгдэх болсон ба энэ үеэс Хинаяна буюу Бага хөлгөний ёс гэсэн нэр томъёо зэрэгцэн гарсан байна. Харин Бага хөлгөнтний хувьд өөрсдийн ёс уламжлалыг Тхеравада буюу Ахмад гэлэнгийн ёс гэж нэрлэж ирсэн ба тэд өөрсдийгөө одоо ч гэсэн ингэж нэрлэдэг хэвээрээ байна. Махаяна нь "Авралын өргөн мөр" гэсэн

¹ Энэ он тооллыг орчин үеийн эрдэмтэдийг тогтоосон хувилбараар авлаа. Үүгээр 1956 онд дэлхий нийтээр Бурханы мэндэлсний 2500 жилийн ойг өргөн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлсэн билээ.

² Брагри Дамцагдорж. "Сав, шим ертөнцийн байдал, шашин гарсан ёс сэлтийг товч төдий үзүүлсэн оюуны харанхуйг арилгагч эрдэнийн зул". Орчуулагч И. Дэмбэрэл. УБ. 2004 он. 34-р тал

утгатай ба Хинаяна нь “Авралын нарийн мөр” гэсэн утгатай төдийгүй энэ хоёр гол ёс нь нэрнээсээ аваад онолын хувьд ялгаатай үзэл баримтлал, тогтсон тааллууд юм.

Дээрх хоёр нэр томъёонд гарч буй мөр гэдгийн хувьд гадаад ертөнцийн бус дотоод сэтгэлийн сайжралын буюу гэгээрлийн шат дараалал гэсэн утгатай. Санскрит хэлний “уана” нь хөлгөн гэсэн утгатай үг юм. Энэ үгийг төвдөөр “тэг” гэх ба Их хөлгөн гэхээр тэгчэн, Бага хөлгөн гэхээр тэгман гэж тогтсон байна. Санскрит утга нь төвд, монгол хэлэнд “хөлөг онгоц” гэдэгтэй дүйцэх ба харин барууны орнуудад энэ үгийн өөр нэг утга болох “хүрдэн” гэдэг үгээр орчуулж хэвшжээ.

Орчин үед Бага хөлгөний ёсны Бурханы сургаал нь өмнөд, зүүн өмнөд азийн орнуудад уламжлагдан ирсэн бол Их хөлгөний ёсны сургаал нь азийн хойд хэсэгт голлон дэлгэрсэн тул баруунд “Northern Buddhism” (“Умардын Буддизм”) гэсэн нэр томъёогоор энэ ёс дэлгэрсэн бүс нутгийн онцлогийг илэрхийлэх болсон юм. Энэ бүс нутагт Хятад, Төвд, Балба, Монгол, Солонгос, Япон орох ба өөрөөр хэлбэл Билиг барамидийн сургаал энэ бүс нутагт дэлгэрчээ.

Билиг барамидийн сургаал нь Их хөлгөний сургаалын үндэс болсон бөгөөд Бага хөлгөний сургаалд байхгүй ялгамжаатай сургаал гэж судар номуудад олонтаа дурдсан байдаг. Дээр дурьдсанчлан хоёр дахь номын хүрдэнээс хойш Их ба Бага хөлгөний ёс зэрэгцэх болсон боловч тухайн үедээ Бага хөлгөний сургаал олныг хамарч өргөн хүрээнд дэлгэрч, их хөлгөний сургаал нь дээд оюунт цөөн шавь нарын хүрэнээс хэтрээгүй ажээ.

Бурхан багш Билиг барамидийн сургаалыг айлдахын өмнө өөрийн суудлаасаа босч суудал руугаа хандан гурван удаа мөргөсөн тухай эрдэмтэн, мэргэд судар номонд олонтоо иш татан дурдсан байдаг. Энэ нь үнэндээ Билиг барамидийн сургаал хэр ач холбогдолтой сургаал болох тухайд шавь нартаа үг хэлээр ярьснаас ч илүү гүн мөн чанарыг нь танилцуулсан үйлдэл болсон хэрэг юм.

Бурхан багшаас түүний ойрын шавь нарын нэг Дондам яндаг бээр:

- Анхны сургаалдаа юмс бүгд мөн чанараасаа бүтсэн гэсэн хирнээ Билэг барамидийн сургаалд юмс бүгд мөн чанараасаа бүтээгүй гэж айлдсан энэ хоёрын ялгааг хэлж өгнө үү? гэж асуухад Бурхан багш түүнд хариулт болгож Билэг барамидийн сургаалыг айлдсан байна.¹ Иймээс Бурхан багшийн анхдугаар ба хоёрдугаар номын хүрдний эргүүлэлт шавь нарын оюуны савд тохирсон ялгаа бүхий номлол болж үлдсэн юм. Энэ ялгаанаас дээрх хоёр хөлгөн тус тусын ёсны сургаал үүсчээ.

Мэргэд их хөлгөний утга чанарыг үг уралдуулан магтсан нь байдаг. Тухайлбал, Энэтхэгийн Чойшид бандида “Үгийг тодруулагч” гэх зохиолдоо “Бурхан 84 мянган номын цогц айлдсаны дотроос ганц Билэг барамид нь эрхэм дээд шавь нарт голчлон айлдсан тул эрхэм, өгүүлэгдэхүүн нь гүн гүнзгий хоосон чанарыг илтэд үзүүлэх тул гайхамшигт, гэгээрэлд хүрэх мөрийн үндсийг таниулснаараа агуу их, их хөлгөний мөр бүгдийг нууц утганд үзүүлснээр гол, төгс сайн гэтлэл болох эс оршихуйн нирвааныг эцсийн чухал хэрэг болгосноороо төгс сайн”² гэсэн байна. Бурханы сургаал бүхэлдээ эрхэм боловч Билиг барамид түүний зүрхэн шим гүн утга болох нь дээрх тодорхойлолтоос харагдаж байгаа юм.

Тэгвэл тэдгээрийн дотроос Бурхан багшийн айлдсан Билиг барамидийн гол утга нь юу байх вэ? гэвэл энэ нь илт, далд гэсэн хоёр утгаар тодорхойлогддог. Энэ нь “шууд утгандаа юмс бүгдийн хоосон чанарыг үзүүлсэн тул хоосон чанарын сургаал хэмээн

¹ А.Батцэнгэл. Билэг барамидийн Энэтхэг сурвалжууд. Энэтхэг Монголын сурвалж соёлын хэлхээ холбоо. УБ. 2005 он. 104-104-р тал

² А.Батцэнгэл. Билэг барамидийн Энэтхэг сурвалжууд. Энэтхэг Монголын сурвалж соёлын хэлхээ холбоо. УБ. 2005 он. 103-р тал

нэрлэгдэх боловч нууц утгандаа дээд гэгээрэлд хүрэх мөрийн дэс дарааллыг үзүүлсэн байна”¹ гэсэн нь тус судар төгс гэгээрлийн хөтөлбөр мөн болох нь тодорхой байна.

Бурхан багш Билиг барамидийн сургаалаа айлдах цаг үед түүний дэргэд шавь нар сууж айлтгалыг сонсож байлаа. Гэхдээ тэрхүү шавь нарынх нь зэрэгцээ тэнгэр, лусын орны шавь нар ч номлолыг бүрэн гүйцэд сонссоноор энэ сургаалыг өөр өөрийн орондоо дэлгэрүүлсэн байна². Тэнгэрийн оронд Билиг барамидийн “Эх” хэмээгч судар ихэд дэлгэрчээ. Энэхүү монголоор “Эх” буюу төвд нэрээрээ “Юм” хэмээгч энэхүү бүтээл нь 9 номоос бүтсэн бөгөөд тэдгээр нь үндсэндээ их, дунд, бага гэсэн гурван гол хэсэгт хуваагдаж нэг бүр нь гурван номноос бүрддэг. Тэдгээрээс юуны өмнө “Юм”-ын Их судрын гурван ботийг тус тусад нь энд дурдъя.

1. “Юм”-ын ихийн их судрыг “Зуун мянган голти” гэж нэрлэнэ. Энэ судар эдүгээ хүний ертөнцөд байхгүй, харин дуса нарын оронд залагдаж байдаг байна. “Юм”-ын ихийн дунд нь “Зуун мянган бумт” ба энэ нь тэнгэр нарын оронд (Сүмбэр уулын дээр оршигч 33 тэнгэрийн орноос дээш буй хүсэлт, дүрст, дүрсгүй орны тэнгэрүүд нь тэнгэр нарын оронд оршин суугчид юм) байдаг. Ихийн бага буюу хураангуй “Юм” гэх судар нь Ганжуурт буй “Бум” судар юм. Тэгэхээр “Юм”-ын их, дунд нь бидэнд уламжлагдан ирж чадаагүй ажээ. Хэдийгээр дэлгэрэнгүй нь уламжлагдаж чадаагүй боловч хураангуй хувилбараас нь тэдний ерөнхий утгыг тодорхойлж болохоор байна. Энэ тухай Төвдийн Жэцал хамба тэргүүтэй мэргэд өөрсдийн судар номондоо дурдсан байна. Төвдийн эрдэмтэн Богд ламын ойрын шавь Жалцавжийн гэгээнтэн (Жалцав дарма ринчен. 1364-1432 он) “Чимгийн хураангуй утга” номондоо “Юм-ын ихийн ихийг Хятадад орчуулсан, ихийн дунд нь Энэтхэгт байсан гэх боловч Төвд хэлнээ орчуулагдаагүй” гэсэн байдгаас³ үзэхэд уг судрын их, дунд нь Энэтхэг оронд их хөлгөн дахин дэлгэрсэн тэр үед байсан боловч хожим устаж үрэгдсэн байх магадлалтай.

2. “Юм” судрын дундын их нь “Хорин мянгат”, дундын дунд нь “Арван найман мянгат”, дундын бага буюу хураангуй нь “Арван мянгат” гэсэн гурван зүйл байна.

3. “Юм” судрын бага буюу хураангуйн их нь “Найман мянгат”, дунд нь “Арван найман аймагт”, бага буюу хураангуй нь “Судрын хураангуй” юм. Эдгээр 9 зүйлийг Билиг барамидийн 9 ном гэж нэрлэх ба тэдгээрийн “номын билиг барамид гэх нь бий.

Дээрх 9 номноос Ихийн хураангуй, дундын гурван ном, багын гурван ном гэх зэрэг 7 ном нь эдүгээ Төвд, Монгол дахь Ганжуурын Билиг барамидийн аймагт орсон байдаг.

Бурхан багшийн айлдсан Билиг барамидийг төвдөөр Парчин гэх ба санскрит нэр нь Пражня прамита гэх ажээ. Сүүлийн үед судлагааны бүтээлүүд нь санскрит нэр томъёог судалгаанд голлон хэрэглэж байна. Энэхүү Пражня прамита буюу Парчиний үндсэн утга юу болох талаар энд тодруулъя. Монголын нэрт эрдэмтэн, лам, цахар гэвш гэсэн нэрээр олны танил болсон Лувсанцүлтэм (1730-1810 он) бээр “ер нь Парчин хэмээх нь Бурхан багшийн гэгээнтэн гурван аймаг “Юм”-д номлосон агуу их явдлын мөрийн утгыг номлосон буй. Тэр нь шарван брадигабуд, бодьсдва нугууд анх өөр өөрийн мөрд орохын аймаг ба завсарт үйл, нисваанис тэргүүтнийг арилгах ба мөрийн онол, эрдэм төрөхийн аймаг, эцэст орчлонгоос танилж, бодийг олохын аймаг ба ялангуяа, бодьсдва нарын таван мөр, арван газар, Бурханы дөрвөн лагшин тэргүүтэн товчилвоос анх шашинд орохын үеэс эцэс Бурханы хутаг олох хүртэл бүгдийг номлосон буй”⁴ гэсэн байна.

¹ А. Батцэнгэл. Билэг барамидийн Энэтхэг сурвалжууд. Энэтхэг Монголын сурвалж соёлын хэлхээ холбоо. УБ. 2005 он. 104-р тал

² Дэлгэрүүлэн найруулсан Г.Пүрэвбат. Шагжаан чадагч Бурханы их намтар. УБ. 2006 он. 483-488-д

³ А. Батцэнгэл, Билиг барамидын энэтхэг сурвалжууд. Энэтхэг Монголын соёлын хэлхээхолбоо, УБ, 2005, 103 дахьтал

⁴ Лувсанцүлтэм. “Зонхавын намтар” 2000 он. УБ. -р тал

2. Билиг барамидийн анхдугаар дэлгэрэлт

Бурхан багш гэгээрснээс нэг жилийн дараа номын хүрдний хоёрдугаар айлтгал болсон гэсэн тооцоо байдаг тулгуурлавал Билиг барамидийн сургаал түүнээс хойш даруй 44 жил Бурхан багшийн шилдэг оюунлаг шавь нарын дунд дэлгэрчээ гэж үзэж болох юм. Харин тэр цаг үеэс хойш хичнээн жил Энэтхэг оронд оршсон талаар энд тодорхойлохыг оролдье.

Төвдийн эрдэмтэн Гүнчин игчааны чойрын дацанг үндэслэсэн багш Гүнчин Жамъян Шадав (1648-1722 он) "Тогтсон тааллын үндэсний аймаг" бүтээлдээ: "Бурхан багш гэгээрэх ёсыг үзүүлсэн тэр жил судрын аймгийн арван газар тэргүүтэй Их хөлгөний ёсны сургаал гарсан бөгөөд Бурхан багш нирваан дүр үзүүлснээс хойш 40 жилийн дараа цагийн хямрал тэргүүтнээс шалтгаалан Их хөлгөний ёс бүдгэрчээ"¹ гэж тодорхойлсон байдаг. Энэ бүхнээс үзэхэд уг сургаал ойролцоогоор 84 орчим жил Энэтхэг оронд оршсон хэмээн тоймлож болох юм.

Бурхан багш нирваан болохын өмнө өөрийн шашныг Маха Кашъяпад даалгасан ба тэрээр уг шашны тэргүүн багшаар томилогдоод дараа жилдээ Бурхан багшийн гэрээсийн дагуу Зарлигийг анх удаагаа хураасан их чуулганыг хийлгэжээ. Уг чуулганаар Ананда судрын аймгийг, Ували винайн аймгийг, Маха Кашъяпа авидармын аймгийг тус тус айлдан танилцуулжээ. Энэ чуулганаар дээрх гурван мэргэдийн айлдварыг тус цуглаанд оролцогсод санал нэгтэй хүлээн зөвшөөрч аймаг сав номлолыг яг түүгээр цаашид авч явах шийдвэр гарснаар өндөрлөсөн байна. Учир нь тэрхүү чуулганд оролцсон 500 архад бүгд Бурхан багшийн сургаалын үндсийг "илүү ч үгүй, дутуу ч үгүй мөн" гэж үзсэн байна².

Судрын аймагт Билиг барамидийн сургаал багтах тул энэхүү чуулганд Билиг барамидын сургаал ч үндсэн гол зүйлд багтан орсон гэж үзэж болно. Энэ үед Судрын аймаг дахь Билиг барамидийн сургаалыг хутагт Ананда барьж байсан нь тодорхой юм. Маха Кашъяпа Зарлигийг хураагаад дараа жил нь таалал болсон ба тэрээр шашныг барих эрхийг Анандад үлдээсэн аж. Ананда ч Бурханы иш айлтгал ёсоор Бурханы шашныг Ганга мөрний дагуу Энэтхэгийн нутагт хамаг амьтнаа номоор тэтгэх тусыг цаглашгүй үзүүлсэн байна. Ананда энэ тухайгаа хожим ийнхүү өгүүлжээ:

*"Аяа, би бээр Чадагч бурханы Судрын аймгийг
Ариунаар огоот хураан номын мөрийг агуулав
Асар өнө удаан болтол нэгээс нөгөөд залгамжлан
Аврал үзүүлэгч Бурханы шашин оршсон болой
Ашид би бээр тус хийгээд буяныг үйлдсэн болой"*

Ийнхүү Ананда Бурханы арслант ширээнээ сууж, шавь нарт номлол түгээн уг шашныг цааш 40 орчим жил тэтгэсэн гэдэг. Энэ он цагийг нягтлан Билиг барамид хичнээн жил оршсон болохыг нягталж болох юм. Төвдийн түүхч Жонан Дараната Гунгаанямбуугын (1575-1634 он) "Энэтхэгийн түүх"-энд: "тэр мэт Ананда дөчин жил шашныг тэтгэсэн"³ гэсэн байдаг. Харин өөр нэгэн намтарт буйг иш татвал: "Ананда бээр Бурхан багшийг нирваан болсноос хойш дөч илүү жил болтол шашныг дэлгэрүүлэн үйлдээд, наян таван нас хүрсэн цагт Хулст ойн цэцэрлэгт суун бүхүйд нэгэн аяга тахимлаг буруу шүлэг уншихийг сонсоод:

¹ Гүнчин Жамъян Шадав. "Тогтсон тааллын үндэсний тайлбар". 106 дахь тал.
² Дэлгэрүүлэн найруулсан Г.Пүрэвбат. Шагжаан чадагч Бурханы их намтар. УБ. 2006 он. 938-939-д
³ Жонан Дараната Гунгаанямбуу "Энэтхэгийн түүх". Орчуулагч Л.Тэрбиш. 2000 он. УБ. 7 дахь тал

-Түүнийг Ялж төгс нөгчсөн зохиосон бус болой хэмээн өгүүлсэнд:

-Үлэмж биетэн чиний ухаан доройтжээ. Оюун чинь өтлөхүйд нэрвэгдэн доройтжээ гэж түүнийг мохоосонд их багш Ананда түүнийг үгийг үл шүүмжлэн гүн уйтгар төрж, өөрийн шашныг Кашьяпад тушаагаад элдэв зүйлийн рид хувилгааныг үзүүлээд Ганга мөрний дунд нирваанд оршсон¹ гэдэг.

Дээрх үйл явдлаас үзэхэд дээд төрөлхтний оюуныг баясган, ухааныг цэлмээх Билиг барамидийн номыг авч явах их хөлгөний залгамж халаа тасалдах ёр дээрх үйл явдалтай холбоотой байж болох юм.

Билиг барамидийн аймаг нь хутагт Анандыг амьд сэрүүн байх үед тодорхой хэмжээгээр доройтож, түүнд шавь олон байсан ч тэдгээр нь их хөлгөний сав бус Бага хөлгөний сав бологсод нь зонхилж байснаас Билиг барамидийн сургаал үүгээр тасалдсан гэж үзэж байна.

Үүгээр Их хөлгөний сургаалын охь манлай болсон Билиг барамидийн номлол Энэтхэг оронд төдийгүй нийт Замбутивд тасалджээ. Энэ тухай Брагри Дамцагдоржийн "Сав, шим ертөнцийн байдал, шашин гарсан ёс сэлтийг товч төдий өгүүлсэн оюуны харанхуйг арилгагч Эрдэнийн зул"-д: "Ялангуяа, их хөлгөн машид доройтож, их хөлгөний мөрийн журам нэрийн төдийхэн (ч үл сонсогдон) сөнөхөд ойртсон² гэж бичсэн байна. Ийнхүү энэ үед их хөлгөний шашин зуу хүрэхтэй үгүй жил оршин тогтоод нэгэн хэсэгтээ тасалдаж мөхөлд орсон түүхтэй.

3. Билиг барамидийн сургаалын хоёрдугаар удаагийн дэлгэрэлт

Их хөлгөний сургаал сургаал доройтоход Билиг барамидийн сургаал доройтож, дахин дэлгэрэх үед хүчтэй дэлгэрч харилцан нягт уялдаатай явж ирсэн зүй тогтол Энэтхэгийн Бурханы шашны түүхэн үйл явцад гарч байжээ. Энэ талаар энд тодруулах болно.

Төвдийн түүхч Жонан Даранатын "Энэтхэгийн түүх" бүтээлд ажиглалт хийхэд Их хөлгөний сургаал Анандаас хойш тасалдсан мэт байдаг ч явцуу хүрээнд Энэтхэг оронд оршин байгаад хожим Бурхан багшийн зарлигийг хураасан гуравдугаар их чуулганы үед дахин гарч ирсэн байна. Энэтхэгийн Ганига хааны үед болсон энэхүү чуулганы үндсэн асуудал нь Бурханы шашинд 18 тогтсон таалал үүсч тэмцэлдээд олон жилийн турш шийдэж чадалгүй маргаантай болсон байсныг нэгтгэх явдал байлаа.³ "Баабо дэ хааны сүүл хийгээд Гаабо, Бадмочэнбо хааны бүтэн насны үе хийгээд Ганига хааны эхнээс хойш, тэдгээр дөрвөн хааны үед өнөд бурсан хуврагууд үргэлж тэмцэлдсэн ба хатуу тэмцэлдээн 63 орчим жил болсон бөлгөө. Түүнээс өмнө хойно тэмцэлдээн алин зохистой буй сэлтийг тооцвол 100 орчим жил болсон бөлгөө.

Түүнээс хойш тэр амирлаж, гуравдугаар хураасны үед 18 аймаг бүгд шашныг ариунаар бүтээн, винайг сударт гаргаж, урьд гарсануудыг ч ариутган шүүсэн бөлгөө. Тэдгээрийн үесэд Их хөлгөний алин зохистой эрхэм зарлиг нь хүмүүний орноо гарсан. Үл төрөхүй номыг тэвчээрийг олсон зарим нэгэн гэлэн өчүүхэн төдий үзүүлсэн бөлгөө. Тийм боловч ихэд дэлгэрээгүй болохоор шравакуудын тэмцэл нь үгүй болой.⁴ хэмээн бичсэнээс үзэхэд Их хөлгөний сургаал Бурханы зарлигийг гуравдугаар хураах их чуулганы өмнө ч хязгаарлагдмал боловч бодитой оршиж байсан гэж үзэж болно.

¹ Дэлгэрүүлэн найруулсан Г.Пүрэвбат. Шагжаан чадагч Бурханы их намтар. УБ. 2006 он. 964-965 тал

² Брагри Дамцагдорж. "Сав, шим ертөнцийн байдал, шашин гарсан ёс сэлтийг товч төдий өгүүлсэн оюуны харанхуйг арилгагч арилгагч Эрдэнийн зул". Орчуулагч И.Дэмбэрэл. УБ. 2000 он. 44 дэх тал.

³ Жонан Дараната "Энэтхэгийн түүх". Орчуулагч Л.Тэрбиш. УБ. 2000 он. 28-30 дахь тал

⁴ Жонан Даранат. "Энэтхэгийн түүх". Орчуулагч Л.Тэрбиш. 2000 он. УБ. 30 дахь тал

Үүнийг тодруулбал, хэдэн зууны дараа Энэтхэгийн алдарт багш нар дээрх орнуудаас дахин залж хүмүүний оронд Их хөлгөний ёсыг дахин дэлгэрүүлжээ. “Болор толь”-д: Бурхан багш таалал төгссөний сүүлд Их хөлгөний шашин тэнгэр хийгээд лусын орноо дэлгэрч агсан бөгөөд бусад тивд ч буй агсан хэмээн номлов. Замбутив үүнээ газарт оршсон бодьсатва ба нууц жам ёсыг баригч нууц тарнийн олон егүзэрс бээр өөрөө бясалгахуй хийгээд хувьтнаа номлох тэргүүтнээр Их хөлгөний шашныг барин арвитгах өчүүхэн агсан мөн боловч ширвакагийн аймаг ихэд дэлгэрсний эрхээр Их хөлгөний аймаг сав сөнөсөн мэт болоод өнө удаан болжээ¹.

Дахин дэлгэрэлтийн түүхийг нягтлан үзвэл Ганига хааны өмнөх Бадмочэнбо хааны үеэс бага зэрэг хойд үед Одивиша оронд Даваасүрэн гэгч хааны үед Их хөлгөний шашин дэлгэрч байсан баримт гарч ирнэ. Тухайлбал, Жонан Даранатын “Энэтхэгийн түүх”-нд: “Даваасүрэн хааны гэрт Манзушри гэлэнгийн ёсоор залраад, их хөлгөний ном алин зохистойг үзүүлсэн ба нэгэн номыг орхисон болой хэмээн гарсныг судрын ёстнууд “Билгийн чанад хязгаарт хүрсэн найман мянгат-д бичсэн болой. Тарничууд нь “да дү сам да ха” буюу тэр ямагтын хураангуй мөн болой хэмээсэн байдаг. Алин мэт боловч үл харшлах төдийгүй урьд мэт ангид буюу хэмээн сэтгэмүй. Энэ нь Бурхан гаслангаас нөгчисний хойно Их хөлгөний ёс хүмүүний орноо гарсан анхдугаар мөн болой”². Дээрх нь их хөлгөний шашин Энэтхэгт Бурхан багшийн зарлигийг гурав дахь удаа хураахын өмнө, Бадмочэнбо хааны үед эхлэн гарсан гэж үзэх баримт юм. Үүнээс хойно буюу Ганига хааны дараа Их хөлгөний шашин хэрхэн дэлгэрсэн талаархи янз бүрийн баримт мөн болой. Тэдгээрээс шаардлагатай гэж үзсэн заримыг энд дурдаж болох юм.

Энэтхэгийн Анга хэмээх орноо төрсөн архад Нанда хэмээгч нь Их хөлгөний номыг баригч нэгэн буй хэмээн сонсож, Их хөлгөний номыг сонсохийн тулд түүнийг урин залсан байна. Тэр цагт хөрш зэргэлдээ нутгуудад ч Их хөлгөнийг номлосон буяны садангууд ч хэмжээлшгүй гарсан ба тэд бүгдээрээ Жанрайсиг, Очирваань, Манзушри, Майдар тэргүүтэн тус бүрээс номыг сонссон аж³ гэснээс үзэхэд их хөлгөний шашин Бурхан багшийн зарлигийг хураасан гуравдугаар чуулганы дараа ихэд түгээмэл болсны баталгаа юм. Энэ үед их хөлгөний томоохон багш нар ч бас төрөн гарсан байна.

Тухайлбал, “Их тойн Авидарга хийгээд Вигадарагадаза, Дижагарагүбда хийгээд Рахуламидра, их гэгээн Сангадала тэргүүтэн номлогч таван зуу гарсан болой”⁴. Энэ үед Их хөлгөний ёсны мэргэд олноор гарахын хамт судар номууд ч олноор гарчээ. Энэ тухай дэлгэрүүлбэл, “Хутагт чухаг дээд хоёр дээдийг давхарласан” хэмээгч нэрт номын нэрийн тоо бум буй. “Мянган бүлэгт” хийгээд “Хутагт Лангараа ажирсан” нэрт, “Хорин таван мянгат”, “Өргөн чимэгт”, “Арван хоёр мянган шүлэгт”, “Ариун номын хураангуй” тэргүүтэн⁵ гэж тэр үед гарсан номын талаар тодорхойлсон байна. Тэдгээр судрыг хэрхэн бүтээсэн талаар “зарим судрын ботиудыг ч тэнгэр, лус, гандирс, мангас тэргүүтэн ангид орнуудаас ялангуяа, лусын орноос зонхи нь гарсан бөлгөө”⁶ гэх мэтийн баримтыг дурдаж болно. Янз бүрийн түүхийн номуудад бичсэнээр Энэтхэг оронд Их хөлгөний ёс тасарч, тэдгээрийг тэнгэр, лусын орноос залсан гэх утга санаа давамгайлдаг.

Их хөлгөний шашныг дэлгэрүүлсэн хоёр гол эрдэмтэнд Нагаржуна, Асанга нар зүй ёсоор багтдаг. Тэднийг Их хөлгөний уламжлалд “их тэрэг хоёр” хэмээн нэрлэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Их хөлгөний ёсны уламжлал Бурхан багшаас хойш тасалдсан байсан

¹ Туган Лувсанчойжижанцан. Болор толь. Орчуулагч С.Шагж. УБ хот. 2006 он. 28 дахь тал.

² Жонан Даранат Гунгаанямбуу. “Энэтхэгийн түүх”. Орчуулагч Л.Тэрбиш. УБ. 2000 он. УБ. 30 дахь тал.

³ Мөн тэнд. 32 дахь тал.

⁴ Мөн тэнд. 33 дахь тал.

⁵ Мөн тэнд. 32 дахь тал.

⁶ 32 дахь тал.

билээ. Энэхүү Их хөлгөний ёсны зам харгуйд шинээр дугуйны мөр гаргасан гэх утгаар дээрх үгээр нэрийдсэн хэрэг.

НОМ ЗҮЙ

1. Дамцагдорж. "Сав, шим ертөнцийн байдал, шашин гарсан ёс сэлтийг товч төдий өгүүлсэн оюуны харанхуйг арилгагч эрдэнийн зул". Орчуулагч И.Дэмбэрэл. Улаанбаатар. 2004 он.
2. А. Батцэнгэл. "Билэг барамидийн Энэтхэг сурвалжууд". Хуудас 102- 108-д "Энэтхэг, Монголь.1 сурвалж соёлын хэлхээ холбоо". Монгол, Энэтхэг хоёр улсын хооронд дипломат холбоо байгуулагдсны 50 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний илтгэлүүдийн эмхтгэл. Улаанбаатар. 2005 он.
3. Цахар гэвш Лувсанцүлтим. "Богд Зонхавын намтар". Улаанбаатар хот. 2004 он.
4. "Шагжаан чадагч Бурханы их намтар". Дэлгэрүүлэн найруулсан бурханч лам Пүрэвбат. 2006 он
5. Жонан Дараната Гунгаанямбуу. "Энэтхэгийн түүх". Орчуулагч Л.Тэрбиш. Улаанбаатар хот. 2001 он.
8. Туган Лувсанчойжиням. "Болор толь". Орчуулагч С.Шагж. Улаанбаатар хот. 2006 он.
9. "Энэтхэгийн наян дөрвөн шидтэний намтар". Улаанбаатар хот. 2005 он. Хөрвүүлсэн О. Сүхбаатар..
10. Г.Лувсанцэрэн. "Мадхьямака философи, түүний онолын үндэс". "Буддын философын түүхээс". Улаанбаатар хот. 1987 он.
11. Нагаржуна. Хаанд илгээсэн захидал. Улаанбаатар хот. 2007 он.
12. Нагаржуна. "Рашааны дусал ба түүний тайлбар". Улаанбаатар хот. 2008 он.
13. Гүнчин Жамъян Шадүв. "Тогтсон тааллын үндэсний тайлбар".

INDIAN PRAJNAPARAMITA AND ITS DEVELOPMENT STAGES

Prajna paramita /Perfection of Wisdom/ is an important practice for bodhisattvas in Mahayana /The Great Vehicle/ Buddhism. Mahayana was founded by Buddha, in Kapilavastu where is located in the south-east of Rajagaha. Buddha addressed to his group of companions led by the pair of disciples Shariputta, Ananda who are wise and powerful arhats and 1250 followers, ordinary believers. Mahayana has been developed by according to their teachings.

The article tell us how can develop Mayahana when Buddha lived. However the practice is discontinued during some period but it could re-developed. As well as the article contains the differences between Mahayana and Hinayana /The Little Way/ and provided Perfection of Wisdom teachings, founded by Buddha.